

“ТУШИГ-УУЛ” ХК-НЫ 2017 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2017 онд үндсэн үйл ажиллагааны чиглэлд заагдсан ажил үйлчилгээг тогтоосон хугацаанд төлөвлөсөн боловч өмнөх оныхоос тодорхой хэмжээгээр буурсан үзүүлэлтэй байна. Энэ нь улс орны эдийн засгийн хямрал, аж ахуйн нэгж иргэдийн худалдан авах чадварын бууралттай холбон дүгнэж байна.

Цаашид үйл ажиллагааны төлөвлөгөөндөө зарим боломж нөхцөлийг судлах, иргэд аж ахуйн нэгжийн төлөөлөгч захирал нартай хамтран ажиллах боломжийг судлах талаар тусгайлан оруулан биелэлтийг хангуулахаар ажиллаж байна.

Ингэх болсон шалтгаан нь ажил үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг алдагдахаас сэргийлэх, өөрийн үйл ажиллагааг сурчилан таниулах, хамгийн ашигтай санал тавих бололцоотой бөгөөд ингэснээр өөрийн үйл ажиллагааг хэвийн хэмжээнд явуулах цаашид компаний стратеги зорилтыг хангахад түлхэц болох боломж юм.

Үндсэн үйл ажиллагаанаас гадна ажилчдын ажлын байран дах хөдөлмөр хамгаалал , эрүүл ахуйн аюулгүй байдлыг хамгаалах ,ажилчдын өдөр тутмын ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар тодорхой ажлуудыг үе шаттай зохион байгуулан ажиллаж байна. Компаний нийт ажиллагсдын тоо : 45

Санхүү байдлын талаарх мэдээлэл :

Компани нь санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар , үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар ,түгээмэл тархацтай нөөц ашигласны албан татвар,агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын тайланг хууль заасан хугацаанд тайлагнаж байна.


2017 онд жилийн эцсийн байдлаар 373,1 сая төгрөгийн өртөгтэй 40 мян м3 элс хайрга борлуулж -24,2 сая төгрөгийн алдагдалтай ажиллаа. Энэхүү алдагдлын гол хүчин зүйл нь үнийн өсөлт , барилгын компаниудын үйл ажиллагаа зогссонтой холбоотой юм.

Компани нь 2016 оны эцсийн байдлаар татвар болон нийгмийн даатгалд дараах байдлаар өртэй байна. Үүнд :НДШ -17,7 сая, ХАОАТ-10,8 сая, ТТНАТ-41,7 сая, НӨАТ-31,3 сая төгрөг.

| Мөрийн дугаар | хөрөнгө ,өр төлбөрийн үзүүлэлт | 2016 оны 12-р сарын 31 | 2017 оны 12-р сарын 31 |
|---------------|--------------------------------|------------------------|------------------------|
| | | | |
| | Эргэлтийн хөрөнгө | 619.10 | 680.00 |
| | Эргэлтийн бус хөрөнгө | 1,475.50 | 1,296.80 |
| | Нийт хөрөнгийн дүн | 2,094.60 | 1,976.90 |
| | Богино хугацаат өр төлбөр | 385.8 | 292.3 |
| | эзэмшигчийн өмч | 1,708.80 | 1,684.60 |
| | Өр төлбөр ба эздийн өмчийн дун | 2,094.60 | 1,976.90 |

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2016 оны 12-р сарын 31 | 2017 оны 12-р сарын 31 |
|---------------|---------------------------------------|------------------------|------------------------|
| | | | |
| | Борлуулалтын орлого (цэвэр) | 538,4 | 516,3 |
| | Борлуулалтын өртөг | 404,1 | 373,1 |
| | Нийт ашиг /алдагдал/ | 134,2 | 143,2 |
| | Түрээсийн орлого | | |
| | Хүүний орлого | 47,6 | 24,6 |
| | Бусад орлого | 7,3 | 16,5 |
| | Борлуулалт, маркетингийн зардал | 120,7 | 114,0 |
| | Ерөнхий ба удирдлагын зардал | 77,0 | 69,9 |
| | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | -56,3 | 24,2 |
| | Орлогын татварын зардал | | |
| | Татварын дараах ашиг (алдагдал) | -56,3 | -24,2 |

Компаний тухай хуулийн 87,89 дүгээр зүйлд заасан их хэмжээний гэрээ хэлцэл хийгдээгүй болно.



Тайлан бичсэн туслахад зурсна
/ Ж.Батсайхан /